

САЙНЦАГААН СУМЫН 8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



Тус цэцэрлэгийг Сайнцагаан сумын 7-р багийн нутаг дэвсгэрт “Чулуутын багш” ХХК-ний боловсруулсан Б-14/2018 шифртэй зураг төслийн дагуу “Монгол дээвэр” ХХК нь барилга угсралтын ажлыг 2018 оны 07-р сараас 2019 оны 06-р сарын 27-ны өдөр хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгч, 08 дугаар сарын 27-ны өдөр үйл ажиллагаагаа эхлүүллээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны 08-р сарын 27-ны А/300 тоот захирамжаар 2019 оны 09-р сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээ, 2019 оны 09-р сарын 01-ний өдөр Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ тус тус авч 2019 оны 08-р сарын 27-ны өдөр цэцэрлэгийн эрхлэгчийн Б/01 тоот тушаалаар 20 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны багш, ажилчдыг сонгон авч ажилд томиллоо. Тус цэцэрлэг нь 5 дахь хичээлийн жилдээ сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

Манай цэцэрлэг нь 100% мэргэжлийн багшаар хангагдаж нийт багшийн 85,7% мэргэжлийн тэргүүлэх, заах аргач зэрэгтэй, Боловсролын тэргүүний ажилтан 2

багш ажиллаж байна. Мөн багш нарын 57,1% нь боловсролын магистр зэрэгтэй багш байна.

СӨББ-ын орчны стандартын шаардлагын дагуу хүүхдэд ээлтэй сурч хөгжих, эрүүл, аюулгүй эко орчинг бүрдүүлэн олон улсын эко сургууль, цэцэрлэг хөтөлбөрт хамрагдан бага, дунд, ахлах, бүлгийн зохион байгуулалтаар 170-186 хүүхдийг бүртгэн авч сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

Цаашид манай хамт олон нь төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, хурдацтай, хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн өөрчлөлттэй уялдуулан ирээдүйн иргэдийг бүтээлч, бие даасан чадамжтай хувь хүн болгон хөгжүүлж төлөвшүүлэхэд нэгэн зорилго чиглэлтэй ажиллаж байна.

Байгууллага хамт олны амжилтаас:

- 2019 онд аймгийн “Хөдөлгөөнт гимнастикийн аварга” шалгаруулах тэмцээний **ДЭД** байр
- 2019 онд Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээний **ТЭРГҮҮН** байр
- 2020 онд “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2020” **БАТЛАМЖ**
- 2020 онд С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын сангийн “Номын буланг моод болгоё” цахим уралдааны **ДЭД** байр
- 2020 онд аймгийн Эрүүл мэндийн газрын “Эрүүл ажлын байр” **ГУРАВДУГААР** зэрэг
- 2020 онд аймгийн “Шилдэг хариуцлагатай албан байгууллага” **ТЭРГҮҮН** байр
- 2020 онд аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга Ц.Мөнхбатын **ТАЛАРХАЛ**
- 2021 онд аймгийн Эрүүл мэндийн газрын “Эрүүл ажлын байр” **НЭГДҮГЭЭР** зэрэг
- 2021 онд сумын Эрүүл мэндийг дэмжигч байгууллага
- 2021 онд аймгийн эрдэм шинжилгээний бага хуралд “Теле хичээлийн үр дүнг сайжруулахад эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт илтгэл **ТУСГАЙ** байр
- 2021 онд “Дундговь-Цахим гимнастрада” Аэробек төрөлд **ДЭД** байр
- 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын **ТАЛАРХАЛ**

- 2021 онд эрхлэгч Л.Оюун аймгийн “Үндэсний бичигтэн шилдэг төрийн албан хаагч” **ТЭРГҮҮН** байр
- 2022 онд аймгийн эрдэм шинжилгээний бага хуралд “Чөлөөт ажиглалтын арга зүйг ахмад багш нарын оролцоотой судлах нь” сэдэвт илтгэл **ДЭД** байр
- Аймгийн “Цахим сургалтын үйл ажиллагаа-2022” уралдааны **ГУРАВДУГААР** байр
- 2022 онд арга зүйч Л.Чимэдцэеэ аймгийн “Үндэсний бичиг үсгийн баяр” олимпиад төрөлд **ХОЁРДУГААР** байр, цахим бичвэр төрөлд **НЭГДҮГЭЭР** байр
- 2022 онд Улсын биеийн тамир спортын хорооны даргын **ТАЛАРХАЛ**
- 2022 онд Байгууллагын нүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр түшинд эрэмбэлэгдэж улсад 21 дүгээрт жагссан.
- 2022 онд сумын “Угийн бичигтэн хамт олон” **ТЭРГҮҮН** байр
- 2023 онд 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн ур чадварын уралдаанд хөгжмийн багш Э.Дашням **ТЭРГҮҮН** байр
- 2023 онд аймгийн эрдэм шинжилгээний бага хуралд “Багшийн хувийн зохион байгуулалт, төлөвлөлт нь ёс зүйн асуудал гарахад нөлөөлсөн байдал” сэдэвт илтгэл **ТУСГАЙ** байр
- 2023 онд арга зүйч Л.Чимэдцэеэ аймгийн “Үндэсний бичиг үсгийн баяр” цахим бичвэр төрөлд **НЭГДҮГЭЭР** байр